



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2019 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А-73

Улаанбаатар хот

Өр, орлогын харьцааны дээд
хязгаарыг тогтоох тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт, 22¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монголбанкны Мөнгөний бодлогын Хорооны 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 1 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Банкнаас шинээр олгох болон нөхцөлийг нь өөрчлөх тэтгэврийн зээлд тооцох өр, орлогын харьцааг 70 хувиас хэтрүүлэхгүй байх, тэтгэврийн зээлээс бусад хэрэглээний зээлд тооцох өр, орлогын харьцааг 60 хувиас хэтрүүлэхгүй байхыг банкны Гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.

2.Энэ тушаалыг 2019 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдүүлэхээр тогтоосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн А-176 дугаар тушаалын 3 дахь заалтыг 2019 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мөнгөний бодлогын газар (Б.Баярдаваа), Хяналт шалгалтын газар (Н.Батсайхан)-т тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТСАЙХАН

14 0770